

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ2024 оны дугаар
сарын -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/849 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Багануур дүүргийн төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Багануур дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй компани, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 545 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх хэсгийн 3 дугаар мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 1,2 дугаар мөрөнд заасан үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллага болон Багануур ХК-ийн халаалтын тариф, 2 дахь хэсэгт заасан ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны дугаар сарын -ний өдрийн
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

Нийслэлийн Багануур дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	3,640.0	
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	43,224.0
		Тогтмол	Төг/м ³	2,461.1
3	Төсөвт байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/ГЖ	36,522.0	

-oOo-

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны дугаар сарын -ний өдрийн
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БОЛОН
АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

Нийслэлийн Багануур дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,000.0
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 23,983.0
		Тогтмол	Төг/м ³ 1,346.0
3	ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/ГЖ	29,234.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, "00"-ын өрөөний халаалт хамаарна) талбайгаар	Төг/м ²	1,400.0
5	Орон сууцны халаалт	Хувьсах	Төг/ГЖ 13,715.0
6	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Халаалтын улиралд	Төг/хүн 4,980.0
		Халаалтын бус улиралд	Төг/хүн 6,971.0
		Зарцуулалтаар	Төг/м ³ 2,570.0
7	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар 5,196.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай өрх	Төг/сар 8,660.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх	Төг/сар 17,318.0